

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Чинзориг Ургийн овог: Боржигин Нэр: Өнөржаргал Хүйс: Эмэгтэй Төрсөн он: 1984 Төрсөн газар: Монгол Улс, Улаанбаатар Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Мөн.
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй.
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй.
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй.
1.6	Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй.

1.7	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
1.8	<p>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>Тийм.</p> <p>Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.10-д “Улсын Их Хурлаас татгалзсан нэр дэвшигчийг дахин нэр дэвшүүлэхгүй.” гэж заасан байх бөгөөд нэр дэвшигч Ч.Өнөржаргал миний хувьд Хууль зүйн байнгын хорооны байгуулсан Ажлын хэсгээс шалгарсан боловч УИХ-ын Хууль Зүйн Байнгын Хорооноос олонхийн санал аваагүй болно. Тодруулбал, Хууль зүйн байнгын хорооноос олонхийн санал аваагүй нь Улсын их хурлаас татгалзсан гэж үзэхгүй.</p> <p>Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогдсон 126 гишүүнээс бүрдэх бөгөөд энэ бүрэлдэхүүнийг “Улсын Их Хурлын нийт гишүүн” гэж ойлгоно.”, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр тогтоолын хэлбэртэй байна.” гэж тус тус заасан</p> <p>Мөн Монгол Улсын Их Хурлын Чуулганы дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. ...”, 133 дугаар зүйлийн 133.6-д “Эрх бүхий этгээд томилгооны шийдвэр гаргахдаа нэр дэвшигчийн сонголын тайлан, Байнгын хорооны санал, дүгнэлт, тэдгээрийн үндэслэл, баримт, мэдээллийг харгалзан үзнэ.” гэж тус тус заасан.</p> <p>Дээрхи процессын дагуу УИХ-аас Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээс хойш УИХ-аас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс татгалзаж байсан тохиолдол гараагүй гэж үзэж байна.</p> <p>Ажлын хэсгийн гишүүд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг зөв хэрэглэнэ гэж найдаж байна.</p> <p>Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.10-д “Улсын Их Хурлаас татгалзсан нэр дэвшигчийг дахин нэр дэвшүүлэхгүй.” гэх зохицуулалт нь Эрх зүйн онолын үүднээс аливаа эрх зүйн хязгаарлалтын тохирсон байх зарчмыг хэтрүүлсэн буюу зөрчсөн байх бөгөөд хүний эрхийг хязгаарласан хатуу зохицуулалт болжээ.</p>

	<p>Орчин үед Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хүний эрхийг хангах үүднээс “ялтай байдал” гэх ойлголт, зохицуулалтыг Эрүүгийн хуулиас хасч, Олон Улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу үйлдсэн гэмт үйлдэлд зөвхөн нэг удаа хариуцлага ногдуулахаар зохицуулсан байдаг.</p> <p>Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаанд хуульчийн хувь нэмрээ оруулан ажиллахаар хүсэлт гаргасан хуульчийн дахин Шүүхийн ерөнхий зөвлөлд нэрээ дэвшүүлэх эрхэд халдах нь хүний эрхийн ноцтой зөрчил бүхий заалт гэж үзэхээр бөгөөд УИХ-ын аливаа татгалзсан шийдвэр нь аливаа этгээдийн цаашидын эрх зүйн байдалд халдахад хүргэжээ.</p> <p>Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.10 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгал хэсгийн -хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, ... эрхэмлэн дээдэлж, 1 дүгээр зүйлийн 2-д “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, 14 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг тус тус зөрчсөн шинжтэй байхыг дурьдаж байна.</p>
--	--

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

<p>2.1</p>	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>МХХ-ны Зөвлөлийн гишүүн, МХХ-ны Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны гишүүн, МХХ-ны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, ХЭҮК-ийн орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүн, хуульч өмгөөлөгч Ч.Өнөржаргал би Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3-т заасан шаардлагыг хангаж байх тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр нэр дэвших хүсэлтээ үүгээр илэрхийлж байна.</p> <p>Улсын Их Хурал 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийг бэхжүүлж, улмаар 2024 онд Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг баталсан.</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөл хамтын удирдлагын байгууллага бөгөөд Шүүхийн эрх мэдлийн хөгжлийн бодлогод заасан зорилгод хүрэхийн тулд хамтын шийдвэр гарган ажиллахад хичээл зүтгэн гарган ажиллах бөгөөд тусгайлан</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “ ... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасны дагуу Шүүгч болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтнуудын ачааллыг багасгах, хүний нөөцийн олон улсын стандартыг нэвтрүүлэн ажилтны илүү цагийг тооцон, илүү цагийн хөлс
------------	--

	<p>тооцон авах процессыг тодорхойлох болгох,</p> <ol style="list-style-type: none"> 2. Шүүхийн ил тод байдлыг ханган ажиллах зорилтыг дэмжин ажиллах боловч МХХ-ын Хуульчдийн эрх ашгийг хамгаалах хорооны гишүүний хувьд шүүгчдийн аюулгүй байдлыг чухалчлах үүднээс шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэхдээ хуралдааныг нэвтрүүлэх журмыг боловсронгуй болгох, 3. Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийх болон хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад өөрийн хувь нэмрийг оруулан идэвхитэй ажиллах, 4. Олон улсын Иргэний эрх зүйн конвенцид нэгдсэн орнуудын хүрээнд иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх талаар хамтран ажиллах боломжийг судлан хилийн чандад иргэний эрх зүйн харилцаанд эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцааг хөгжүүлэх дээрхи саналуудыг Шүүхийн хамтын удирдлагад хүргүүлэн ажиллах болно. <p>Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулан ажиллахад тодорхой туршлагатай болохыг дурьдаж байна.</p> <p>Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, таниулах болон Шүүхийн төсвийн асуудалд анхаарал хандуулах нь хуульч бүрийн үүрэг гэж үздэг бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн болсон тохиолдолд Шүүхийн эрх мэдлийн хөгжлийн бодлогод заасан зорилт бүрийг үр нөлөөтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэхийн төлөө хичээл зүтгэл гаргаж ажиллахаа үүгээр илэрхийлж байна.</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөл нь Монголын хуульчдын холбоонд шүүгчдийн сургалтын төлбөрийн асуудал олон жил үргэлжилж ирсэн бөгөөд энэ асуудал нь Монголын хуульчдын холбооны санхүүгийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа тул Сангийн яаманд уг асуудлыг тавьж боломжит байдлаар өр, авлагын асуудлыг хурдан шийдвэрлүүлэхэд санаачлагатай ажиллах болно.</p>
--	--

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <p>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан

	<p>таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.</p> <p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <ol style="list-style-type: none"> 1. 2022-2025, 2025 оноос одоог хүртэл МХХ-ны Зөвлөлийн гишүүн 2. 2019 оноос одоог хүртэл Өмгөөллийн “Юзисан партнерс” ХХН-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, 3. 2014-2018 он- Өмгөөллийн “Соёмбо легал партнерс” ХХН-ийн өмгөөлөгч, 4. 2012-2013 он-Сүхбаатар дүүргийн Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч. 5. 2010-2012 он-Сүхбаатар дүүргийн Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч С.Юмжирмаагийн туслах өмгөөлөгч, 6. 2008-2010 он-Монголын өмгөөлөгчдийн холбооны Мэдээллийн төвийн ажилтан. <p>Хамтран ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай хүний нэрс</p> <ol style="list-style-type: none"> 1. Өмгөөллийн “Юзисан партнерс” ХХН-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байсан Н.Өлзийжаргал. [REDACTED] 2. Ахмад өмгөөлөгч С.Юмжирмаа. [REDACTED] 3. МӨХ-ны Ерөнхийлөгч асан Б.Пүрэвням. [REDACTED] 4. МХХ-ны Тамгын газрын дарга Ш.Жолбарс. [REDACTED] 5. МХХ-ны гишүүн хуульч, өмгөөлөгч Г.Мөнхболд. [REDACTED]
3.2	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>Олон нийт болон Хүний эрхийн байгууллагын гишүүнээр сонгогдон ажилласан байдал:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2026 оны 5 дугаар сар. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Сонин, сайт, сэтгүүлийн Ёс зүйн хорооны гишүүн /Олон нийтийн төлөөлөл/ /ХЭҮК-ийн комиссын Хүний эрх хамгаалал хариуцсан гишүүн С.Дондов/ 2. 2024 оны 8 дугаар сараас 2026 оны 2 дугаар сар. Хүний эрхийн үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүн. /Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа/
3.3	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он</p>

<p>дарааллаар бичнэ.</p> <p>2009 оноос Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн.</p> <p>2010 онд Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан.</p> <p>2010 оноос Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч,</p> <p>2014 оноос Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч.</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<p>4.1</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил</p> <p>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. <p>1. 2010 оноос хойш өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд одоогийн байдлаар давхардсан тоогоор 250 гаруй эрүү, иргэн, захиргааны хэрэгт өмгөөлөгчөөр оролцсон. /www.shuukh.mn/</p> <p>Өмгөөллийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалан, мэргэжлийн үйл ажиллагааг 17 дахь хэвийн үргэлжлүүлэх нь хууль зүйн өндөр мэргэшилд тооцогдоно гэж үзэж байна.</p> <p>2. Монгол Улсын Их Хурал 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Ази тивд анх удаа Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хүний эрхийн Үндэсний Комиссын /цаашид "Комисс" гэх/ дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо /цаашид "Хороо" гэх/ ажиллана.”, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д “Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Комисс батална.”, 11.4-д “Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо нь тус тусын хуралдаанаараа нэр дэвшигчээ шалгаруулж Комиссын хуралдаанд санал болгоно.” гэж заасны дагуу Монголын хуульчдын холбооны төлөөлөл болон 2024 оны 9 дүгээр сараас эхлэн ХЭҮК-ын дэргэдэх орон тооны бус гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд Хүний эрх хамгаалагчийн хорооны дүгнэлт 5</p>
-------------------	---

гаргахад хамтран оролцоод байна.

3. МХХ-ны гишүүн хуульчдын хамт Монгол Улсын нийт шүүгчдийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар” гаргах тухай 11 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “ ... шударга ёс, тэгш байдлыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “ ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй”, 67 дугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.”, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд ..., төрийн байгууллагын бусад шийдвэр, ... бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчсөн тухай мэдээлэл гаргасан бөгөөд уг мэдээлэлд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2022 оны ... дугаар сарын ...ны өдөр маргаан үүсгэсэн. Уг мэдээллийн дагуу цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.
4. “Эмнести интернейшнл-Монгол” НҮТББ-ын хуульчдын бүлгийн гишүүний хувьд Хүний орон байртай байх эрхийн сургагч багш бөгөөд 2021 онд тус байгууллагад хандсан ХУД-ын “Нэхмэлийн шар” гэж нэрлэгдсэн оршин суугчдын орон байртай байх эрх зөрчигдсөн асуудлаар эрх зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байсан бөгөөд 2021 онд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.

Хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллахдаа газар эзэмших эрх нь зөрчигдсөн иргэнд Хууль зүйн туслалцааны төвөөс эрх зүйн туслалцаа үзүүлэхээр заасан байсныг Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол” гэх өөрчлөлтийг оруулах саналыг гаргаж, Ажлын хэсгийн гишүүд уг саналыг дэмжиж, улмаар 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн Улсын их хурлын чуулганаар Хууль зүйн туслалцаа тухай хууль батлагдсан бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө /орон байртай байх эрх буюу ашиглалтын шаардлага хангаагүй орон сууцанд амьдарч байсан иргэдийн орон сууцыг орон сууцаар солих, нүүлгэн шилжүүлэх зэрэгт төлбөрийн чадваргүй эрх нь зөрчигдсөн иргэд хууль зүйн туслалцааг Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нараас эрх зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авах хууль зүйн үндсийг бий болгосон болно.

Энэ нь нөгөө талаас Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нарын өмгөөллийн туслалцааг эрүүгийн эрх зүйн салбар эрх зүйгээр хязгаарлахгүйгээр буюу захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшин ажиллах, ур чадвараа хөгжүүлэх хөшүүргийг бий

болгосон гэж үздэг.

5. Өмгөөллийн тухай хуульд заасан Өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа алдагдсан талаар өмгөөлөгч А.Пүрэвдуламын хамт “Шүгэл үлээж”, өмгөөлөгч нарын хамт Хэвлэлийн бага хурал хийж, өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа хэрхэн зөрчигдсэн талаар мэдээлэл хүргүүлсэн бөгөөд 2021 оны Хүний эрхийн төлөв байдлын илтгэл дээрх асуудлыг тусгуулсан.

ХЭҮК-ийн Хүний эрх хамгаалагчийн асуудал гишүүн С.Дондов 2025 онд Өмгөөлөгч-хүний эрх хамгаалагчийн эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаархи судалгааны ажлыг санаачлан хийсэн бөгөөд МХХ-ны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны үйл ажиллагааны хүрээнд Эрүү шүүлтгүй Монгол Улс-Өмгөөлөгчийн оролцоо Өглөөний уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Мөн УИХ-Хууль зүйн байнгын хорооны дэргэдэх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсан.

Дээрхи Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өмгөөлөгч нарын үйл ажиллагааны ажиллах нөхцөл байдал эерэг өөрчлөлт гарсан гэж үздэг.

6. Улаанбаатар хотод 2022 оны 4 дүгээр сарын 7-8-ны өдөр болсон иргэдийн Жагсаал цуглааны үед буюу 2022 оын 4 дүгээр сарын 7-8-нд шилжих шөнө Цагдаагийн байгууллагаас жагсаал цуглааныг тараах үеэр Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Өмгөөлөгч нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ.” Гэж заасныг дагуу Чингэлтэй дүүрэгт байрлах Түр саатуулах 111 дүгээр төвд саатуулагдсан иргэдэд Эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллахыг нийт өмгөөлөгч нарт уриалан улмаар 10 өмгөөлөгчийн хамт нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд уг нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны талаар ХЭҮК-д 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 04/51 дугаартай албан бичиг хүргүүлсэн бөгөөд уг ажиллагаанаас эхлэн аливаа жагсаал цуглааны үед Өмгөөллийн байгууллага, ХЭҮК, Цагдаагийн байгууллага хамтран Жагсаал цуглааны үед хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэн хамтран ажиллах эхлэл тавигдсан бөгөөд 2022 оны 12 дугаар сард Чингисийн талбайд болсон иргэдийн Жагсаал цуглааны үер МӨХ, ХЭҮК, Цагдаагийн байгууллага хамтран ажиллаж, жагсаал цуглааны үеэр иргэдэд Жагсаал, цуглаанд тайван оролцох талаар мэдээлэл сурталчилгааг хүргэн, жагсаал цуглаанд оролцогчдод шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлэхэд бэлэн байдлыг ханган ажиллахад өмгөөлөгчийн хувиар хамтран ажилласан.

2023 оны 6 дугаар сард Хэвлэлийн хүрээлэнгийн дэргэд Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн төлөөх хуульчдын сүлжээг

байгуулан , улмаар Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн төлөөх Олон улсын сүлжээнд нэгдсэн болно.

7. 2010 онд МҮЭХ, Фридрих Эбертийн сангаас хамтран зохион байгуулсан Хөдөлмөрийн эрх зүйн мэргэшсэн өмгөөлөгч бэлтгэх сургалтад хамрагдаж байсан бөгөөд УИХ-аас 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2022 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес академитай хамтран “Хөдөлмөрийн хуулийн цогц сургалт”-ыг 50 орчим ААН-ийн төлөөлөлд, “Чингис хаан” Шинэ нисэх онгоцны буудал-НҮБИА Улаанбаатар ХХК-ийн хамт олон, “Гранд групп” ХХК-ийн нийт 50 гаруй ажилтан хүргэж зохион байгуулсан.

Хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр идэвхитэй өмгөөллийн туслалцаа үзүүлэн ажилладаг бөгөөд Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Өмгөөлөгч нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ.” гэж заасныг дагуу шүүхийн захиргааны ажилтнуудын Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “ ... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах” эрх нь зөрчигдсөн гэж үзэж 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Засгийн газрыг хариуцагчаар татан “Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлээгүй хууль Засгийн газрын эс үйлдэхүйн улмаас хохирсон хүнд учирсан хохирлыг гаргуулахыг даалгах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан.

Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн аваагүй боловч тухайн асуудлаар Шүүхийн захиргааны ажилтны холбоо ТББ Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаагүй байгаа буюу Шүүхийн захиргааны ажилтнуудын Монгол Улсын Үндсэн хуульд заасан “цалин хөлс авах” эрх сэргээгдээгүй байна.

Монгол Улсын Дээд шүүхийн 2023 оны 07 сарын 03 өдрийн тогтоолоор Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах хүрээнд Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Өмгөөлөгч нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ.”, 29.2-д “Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл батална.” гэж заасныг хэрхэн хэрэглэх талаар тайлбар гарсан.

8. МХХ-ны 5 дугаар Их хурлаас МХХ-ны Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хорооны гишүүнээр сонгогдсон бөгөөд уг хорооны үйл ажиллагааны хүрээнд ШЕЗ-тэй хамтран 2024 оны 9 дүгээр сард “Шүүхийн байрны нөхцөл байдал” хэлэлцүүлэг, нөлөөллийн ажлыг хамтран зохион

	<p>байгуулсан бөгөөд шүүхийн төсвийн асуудлаар хуульчийн байр суурийг идэвхитэй илэрхийлдэг.</p> <p>9. 2024 оны 1 сард Хуульчдын клуб лобби клубыг санаачлан байгуулсан бөгөөд Хуульчдын клуб нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд хуульчдын оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилготой бөгөөд их дээд сургуулийн 3 дугаар түвшний оюутан, эрх зүйч, хуульчдын идэвхитэй оролцоог дэмжин ажиллаж байна.</p> <p>Хуульчдын клуб нь хуульчдын санаачлага болон манлайлалыг дэмжих, оролцооны тэгш байдлыг хангах үүднээс бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй бөгөөд дараах үйл ажиллагааг зохион байгуулаад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хуульчдын хүрээнд Эрх зүйт ёсыг бэхжүүлэхүй цуврал уулзалт ярилцлагыг Үндсэн хуулийн хяналт ба Цэц, Прокурор сэдвээр 2 удаагийн уулзалт, - МХХ-ны сайн дурын хороодтой хамтран Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн хүрээнд 3 удаагийн Өглөөний уулзалт, - Сэтгэлзүйчтэй ярилцах өдөр-Өглөөний уулзалт, - Хууль зүйн англи хэлний 1 удаагийн сургалт, - Хуулийн их сургуулиудын оюутнууд дунд “Хууль ба эдийн засаг” сэдвээр 2 удаагийн, “Эрх зүйн философийн цуврал семинар” 2 удаагийн уулзалтыг тус тус зохион байгуулаад байна. <p>Хуульчдын клубын үйл ажиллагаагаа явуулахад санхүүгийн дэмжлэг болгох үүднээс эхлүүлсэн ажил бол “Фемида” брэнд юм. Эдүүгээ Эрх зүйч мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах “Фемида” брэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргээд байгаа болно.</p> <p>10. Үндсэн хуулийн цэцэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалт, Өмгөөллийн тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл заалт, Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл заалт нь Үндсэн хууль зөрчсөн талаар мэдээлэл гаргаж байсан болно.</p>
<p>4.2</p>	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. -Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл,

нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.

2025.07.04- Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Өөрийгөө хамгаалах үүднээс зэвсэг өмчлөх, эзэмших эрх иргэнд байхгүй.

2025.05.14-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал:Тагнуулын байгууллага иргэдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлдэл хийгээгүй атглаа мөрдөн шалгах чиг үүрэгтэйгээр оролцдог нь учир дутагдалтай.

2025.04.07-Хэвлэлийн хүрээлэн. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн төлөө үндэсний сүлжээний гишүү, өмгөөлөгч Ч.Өнөржаргал: Хэвлэлийн эрх чөлөөний баталгааг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Хариуцлагын механизмгүйгээр Хэвлэлийн эрх чөлөөний баталгаа хангагдах бололцоогүй юм.

2025.01.29-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Ерөнхий сайдын шүүх эрх мэдлийн тогтолцоо руу дайрч, заналхийлж байгаа үйлдэл хэрээс хэтэрч байна.

2025.01.06-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Т.Аюурсайхан нар холбогдох эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх үнэн, зөв шийдвэрлэсэн учраас УДШ дахин хүлээн авч хянах шаардлагагүй гэж үзсэн.

2024.04.23-Өдрийн сонин. Нэр дэвшигчид өдөр тутмын сонинд сурталчилгаагаа нийтлүүлэх нь шударгаар өрсөлдөх боломжийг бий болгоно.

2023.12.08-Монгол Улсын ерөнхийлөгч, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн У.Хүрэлсүхэд илгээсэн нээлттэй Өргөдөл

2023.08.08-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэгт авлига өгсөн хүн нь үйлдлээ хүлээн зөвшөөрсөн учраас бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх ёстой.

2023.07.20-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнуудаас үерийн улмаас учирсан хохирлыг нэхэмжлэх боломжтой.

2022.11.02-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал:Х.Нямбаатар сайдын үйлдэл хөрөнгө оруулагчдад ээлтэй гэдгээ харуулах биш, хуулийн

	<p>байгууллагууддаа халдсан явдал боллоо.</p> <p>2022.06.02-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг хасна гэдэг гэмт хэрэгтэй тэмцэх төрийн хүчийг сулруулна.</p> <p>2022.02.24-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Хүүхдийнхээ цэцэрлэгт хандив өгсөн 12 эцэг эх Эрүүгийн хариуцлагад татагдаад байна.</p> <p>2021.12.28-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлээр илүү цагийн хөлс гэхэд 84 хувиар өссөн дүнтэй байна.</p> <p>2021.12.22-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: ШЕЗ-ийн дарга Д.Зүмбэрэллхам журмыг өөртөө ашигтайгаар тайлбарлаж хуульчдыг, иргэдийг доромжилж байна.</p> <p>2021.10.20-Өдрийн сонин. Хуульч Ч.Өнөржаргал: Төр шүгэл үлээгчээ хамгаалах биш, намнаж эхэлж байна.</p>
4.3	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ) Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Тийм.</p> <ul style="list-style-type: none"> - ХЗДХЯ. Хуульч сонгон шалгаруулах ажлыг эрхлэх орон тооны бус зөвлөл 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдөр. Хуульчийн №4469 гэрчилгээ олгогдсон. - Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар тушаалаар 1590 дугаартай Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа болно.
4.4	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</p> <p>МУИС-ХЗС Хууль ухааны магистр /Нийтийн эрх зүй/ МУИС-ХЗС Эрх зүйн бакалавр</p>
4.5	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй.</p>

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

-төрийн албан хаагчийн анкет;
-иргэний үнэмлэхийн хуулбар;
-нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

-эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

-хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

-эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
-энэхүү загварт заасан баримт бичиг;
-холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: ЧИНЗОРИГ

Өөрийн нэр: ӨНӨРЖАРГАЛ

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026.05.27

---oOo---